



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/202

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ховд аймагт жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг 100 буудалт даамны өсвөрийн аварга шалгаруулах тэмцээнд 1 500 000 төгрөгийг зарцуулсугай.

2.Уг арга хэмжээнд шаардагдах 1 500 000 төгрөг /нэг сая таван зуун мянган/-ийг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөтөлбөр төсөл арга хэмжээний 5.17-д заасан "Спортын аварга" хөтөлбөрөөс тооцож олгохыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д, Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

3.Тэмцээнийг өндөр хэмжээнд зохион байгуулахыг аймгийн Даамны холбооны тэргүүн /У.Болдбаяр/-д, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/202 Ch
02 00930